

+БАТЛАВ.
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГА

..... Б.БИЛГҮҮН

БАТЛАВ.
.....
/АЛБАН ТУШААЛТНЫ НЭР/

ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН ШАЛГАЛТ БАТАЛГААЖУУЛАЛТ, ШАЛГАЛТ ТОХИРУУЛГА ХИЙХ ГЭРЭЭ

20....оны дугаар сарын өдөр

№.....

Улаанбаатар хот

Нэг талаас Стандарт, хэмжил зүйн газар, Улсын бүртгэлийн 9070002082, Регистрийн 9096035 дугаартай, түүнийг төлөөлж Хэмжил зүйн бодлогын газрын дарга Д.Наангэрэл (цаашид “Гүйцэтгэгч” гэх), нөгөө талаас Улсын бүртгэлийн, Регистрийн дугаартай, түүнийг төлөөлж /албан тушаал, нэр/ (цаашид “Захиалагч” гэх) нар Хэмжил зүйн тухай хуулийн 8, 10, 14, 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалт, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны А/136 дугаар тушаалаар баталсан “Хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийх журам” болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Захиалагчийн хэмжих хэрэгслийг хүлээн авах, баталгаажуулалт, шалгалт тохируулгад хамруулах үйлчилгээ үзүүлэх, буруу хэмжлийн сөрөг үр дагавраас эдийн засаг, нийгмийн болон үйлчлүүлэгч, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2 Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт, засвар тохируулгын ажлуудыг хооронд нь уялдуулах зорилгоор “Захиалагч”, “Гүйцэтгэгч”, Хэмжих хэрэгслийг засварлах эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудын хооронд турвалсан гэрээ байгуулж болно.

1.3 Хэмжих хэрэгслийг тухайн онд **Шалгалт баталгаажуулалтад** хамруулах графикийг нэгдүгээр, **Шалгалт тохируулгад** хамруулах график хоёрдугаар хавсралтад зааснаар захиалагч, гүйцэтгэгч харилцан тохиролцож батална.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1. Хэмжил зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг баталгаажуулалт хоорондын хугацаанд дээрх хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасны дагуу анхдагч болон ээлжит баталгаажуулалтад заавал хамруулах ба 22 дугаар зүйлийн 22.2.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1-т заасныг үндэслэн өөрийн хэмжих хэрэгслээ шалгалт тохируулгад энэхүү гэрээний дагуу хамруулж болно.

2.2 Хэмжил зүйн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.9-д заасны дагуу хэмжих хэрэгсэлд ээлжит шалгалт баталгаажуулалт, шалгалт тохируулга хийхтэй холбогдон гарсан зардлыг Захиалагч бүрэн хариуцна.

2.3 Өөрийн байгууллагад ашиглаж байгаа хэмжих хэрэгслийн судалгаанд үндэслэн тэдгээрийг ээлжит баталгаажуулалтад бүрэн хамруулна.

2.4 Хэрэв хэмжих хэрэгслийг эзэмшигч, ашиглагч нь худалдааны лангуу, талбай түрээслэх буюу тодорхой нутаг дэвсгэрт өөрийн үйлчилгээг үзүүлдэг бол (зах, худалдааны төв, орон сууцны контор, цахилгаан, дулаан, уур, ус түгээх сүлжээ, дүүргийн ХҮТ /хэрэглэгчдэд үйлчлэх төв/ г.м. .) хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрээ, графикийг эзэмшигч, ашиглагчийг төлөөлөн нэг Захиалагч хариуцан хийж болох бөгөөд энэ тохиолдолд баталгаажуулалтын төлбөрийг тухайн хэмжих хэрэгслийг ашиглагч, эзэмшигч төлнө.

2.5 Эвдэрсэн буюу буруу ажиллагаатай хэмжих хэрэгслийн засварын ажлыг ээлжит шалгалт баталгаажуулалт, шалгалт тохироулга хийлгэхээс өмнө хэмжих хэрэгслийг засварлах эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлсэн байна.

2.6 Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт болон шалгалт тохироулгыг улсын шалгагч, эсвэл шалгалт тохироулгын ажилтан ашиглалтын байранд нь очиж гүйцэтгэх тохиолдолд ажлаа саадгүй явуулахад нь Захиалагч дараах дэмжлэг, туслалцаа үзүүлнэ. Үүнд:

2.6.1 Шаардлагатай үед Гүйцэтгэгчийн ажлын этalon, туслах багаж хэрэгслийг шалгалт баталгаажуулалт, шалгалт тохироулга хийх байранд аваачих, буцааж хүргэх, ажлын шаардлагаар эталоны ажлын байранд хадгалах бол бүрэн бүтэн байдлыг хариуцах.

2.6.2 Шалгалт баталгаажуулалтын суурин ажлын этalon төхөөрөмжийг Гүйцэтгэгчид ашиглуулах.

2.6.3 Шалгалт баталгаажуулалт хийхэд шаардагдах ажлын өрөө байр, туслах ажилтныг гаргаж өгнө.

2.7 Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайланг Хэмжил зүйн төв байгууллагад сар бүрийн 30-ны өдрийн дотор энэхүү гэрээний гуравдугаар хавсралтад заасан мэдээллийг бүрэн гүйцэд оруулан цахимаар хүргүүлнэ.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх, хүлээх үүрэг

3.1. Захиалагчтай байгуулсан гэрээ, графикийн дагуу хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт, шалгалт тохироулгын ажлыг эрх бүхий хэмжүүрийн улсын шалгагч, шалгалт тохироулгын ажилтан шалгах аргын үндэсний стандарт, аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ.

3.2. Хэмжих хэрэгслийн анхдагч болон ээлжит шалгалт баталгаажуулалт, шалгалт тохироулгыг гүйцэтгэхдээ улсын баталгаатай ажлын этalon хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглана.

3.3. Хэрэв хэмжил зүйн ажил, үйлчилгээний эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагад засвар, тохироулгад хамрагдаж байгаа хэмжих хэрэгсэл нь засварлах боломжгүй бол тухайн хэмжих хэрэгслийг хэрэглээнээс хасах “Мэдэгдэл” олгоно.

3.4. Захиалагчийн зүгээс энэхүү гэрээгээр тохиролцсон үүргээ биелүүлээгүй, гэрээнд заасан төлбөрөө төлөөгүй, гэрээний 2.7-д заасан гүйцэтгэсэн ажлын тайлангаа тогтоосон хугацаанд ирүүлээгүй тохиолдолд хэмжих хэрэгсэлд нь шалгалт тохироулга, шалгалт баталгаажуулалт хийхгүй.

3.5. Захиалагчийн хэмжих хэрэгслийг СХЗГ-ын байранд шалгуулах үед “Хэмжүүр хүлээн авах” ажилтан хүлээн авч шалгалт баталгаажуулалт, шалгалт тохироулгыг ажлын 3-5 өдөрт багтаан гүйцэтгэж буцаан олгоно. /хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт, шалгалт тохироулга хийх улсын шалгагч, шалгалт тохироулгын ажилтан хүндэтгэн үзэх шалтгаантайгаар ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй байгаа тохиолдолд энэ тухай мэдээллийг Хэмжүүр хүлээн авах ажилтан Захиалагчид амаар болон бичгээр мэдэгдэнэ./

3.6. Хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт, шалгалт тохироулга хийх улсын шалгагч, шалгалт тохироулгын ажилтан нь ажил үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай бичгээр удирдлагадаа мэдэгдэнэ.

Дөрөв. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

4.1 Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт, шалгалт тохироулгын ажил үйлчилгээний төлбөрийг “Хэмжил зүйн ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 117 дугаар тушаалын дагуу тооцно. Эрх бүхий этгээдээд төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоосон бол сүүлийн баталсан шийдвэрийг мөрдөнө.

4.2 Энэхүү гэрээний дагуу хэмжих хэрэгслийн **Шалгалт тохироулгын төлбөрт** (тоо болон үсгээр) төгрөг, **Шалгалт баталгаажуулалтын төлбөрт** (тоо болон үсгээр) төгрөг, унааны зардалд

..... (тоо болон үсгээр) төгрөг, нийт
..... (тоо болон үсгээр) төгрөгийг “Гүйцэтгэгч”-ийг ажлаа хийж гүйцэтгэснээс хойш ажлын 5 (тав) өдрийн дотор “Төв төрийн сан банк” –ны 100900009012 тоот дансанд (СХЗГ регистр 9096035) нэхэмжлэлийн дагуу шилжүүлэх буюу эсхүл бэлэн мөнгөний баримтаар бэлнээр төлнө.

Тав. Гэрээний хугацаа

- 5.1 Энэхүү гэрээг талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн дагаж мөрдөх бөгөөд гэрээ нь 1 (нэг) жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 5.2 Гэрээний хугацаа дуусгавар болсны дараа “Захиалагч” нь гэрээ, графикийн гүйцэтгэлийн тайланг дараа оны гэрээ, графикийн санал, хэмжих хэрэгслийн судалгааны хамт СХЗГ-т албан бичгээр ирүүлж талууд гэрээний хэрэгжилтийг хамтран дүгнэнэ.
- 5.3 Энэхүү гэрээний 1, 2, 3 дугаар хавсралт нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд Захиалагчийн хүсэлтээр гэрээний хавсралтад өөрчлөлт оруулсан бол шалгалт баталгаажуулалт, шалгалт тохируулга хийх болон төлбөрийн талаарх асуудлыг нэмэлт гэрээгээр зохицуулна.
- 5.4 Энэхүү гэрээ, графикийг “Захиалагч”, “Гүйцэтгэгч” урьдчилан тохиролцож урд оны ... дугаар сарын ... -ны өдрийн дотор байгуулна.

Зургаа. Бусад зүйл.

- 6.1 Гэрээг хоёр хувь үйлдэж, нэг хувийг Гүйцэтгэгч, нөгөө хувийг Захиалагч тал хадгална.
- 6.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргаантай асуудлыг талууд зөвшилцэх замаар шийдвэрлэнэ. Хэрэв талууд зөвшилцэлд хүрч чадахгүй тохиолдолд асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

Гэрээ байгуулсан талуудыг төлөөлж:

Гүйцэтгэгчийг төлөөлж:
СХЗГ-ын Хэмжил зүйн бодлогын газрын
дарга (.....)
..... Д.Нарангэрэл
СХЗГ-ын Санхүүгийн хэлтсийн дарга (.....)
..... О.Оюунтуяа
Захиргаа, удирдлагын газрын эрх зүйн
асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
..... Б.Эрхүү

Хаяг: Стандарт, хэмжил зүйн газар
Энхтайвны өргөн чөлөө - 46А
Улаанбаатар 13343, Монгол Улс
Данс: Төв төрийн сан банкны
100900009012 тоот данс
Харилцах утас: 51-263792
Цахим шуудангийн
хаяг: info@masm.gov.mn
цахим хаяг: www.masm.gov.mn

Хаяг:
Данс:
Регистрийн дугаар:
Телефон утас:
Вебсайт:
Цахим шуудангийн хаяг:

ШБШТ/04- дугаартай гэрээний нэгдүгээр хавсралт

**БАТЛАВ.
СХЗГ-ЫН ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН ШАЛГАЛТ,
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА**

БАТЛАВ. “ХХК-ИЙН ЗАХИРАЛ /нэр, албан тушаал/

ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙГ 20... ОНД ШАЛГАЛТ БАТАЛГААЖУУЛАЛТАД ХАМРУУЛАХ ГРАФИК

/Бүх хэмжлийн төрлөөр/

ШБШТ/07- дугаартай гэрээний хоёрдугаар хавсралт

БАТЛАВ.
СХЗГ-ЫН ХЭМЖИЛ ЗҮЙН БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА

БАТЛАВ. “ХХК-ИЙН ЗАХИРАЛ

ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙГ 20 ... ОНД
ШАЛГАЛТ ТОХИРУУЛГАД ХАМРУУЛАХ ГРАФИК

/Бүх хэмжлийн төрлөөр/

Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайлан ирүүлэх маягт

**ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН ШАЛГАЛТ БАТАЛГААЖУУЛАЛТ, ШАЛГАЛТ
ТОХИРУУЛГА ХИЙСЭН ОНЫ ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ**

20....оны.... сарын....өдөр

Дугаар:

Улаанбаатар хот

Стандарт, хэмжил зүйн газар', "....." ХХК-ийн хооронд байгуулсан
оны дугаартай хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт, шалгалт тохируулга хийх
гэрээний хэрэгжилтийг дараах байдлаар дүгнэв. Үүнд:

1. Хэмжил зүйн тухай хуулийн хүрээнд тухайн байгууллагын хэмжих хэрэгслийн ээлжит шалгалт баталгаажуулалт, шалгалт тохируулгын ажлыг СХЗГ-ын улсын шалгагч шалгах аргын улсын стандарт, аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн байна.
2. Захиалагч тал нь өөрийн ашиглаж байгаа хэмжих хэрэгслийг шалгалт, тохируулга баталгаажуулалтад бүрэн хамруулж, холбогдох ажилтнуудыг шаардлагатай сургалтад хамруулж ажилласан.
3. Гэрээний дагуу онд шалгалт тохируулга, баталгаажуулалтын ажлын төлбөр болох нийт төгрөгийг СХЗГ-ын 100900009012 дансанд шилжүүлсэн.
4. Бусад

Гэрээ дүгнэсэн:

Гүйцэтгэгч байгууллагыг төлөөлж:

Хэмжил зүйн бодлогын газрын дарга

Д.Нарангэрэл
СХЗГ-ын Санхүүгийн хэлтсийн дарга

.....О.Оюунтуяа

Захиалагч байгууллагыг төлөөлж:

"....." ХХК-ийн

Захиргаа, удирдлагын газрын эрх зүйн
асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Эрхүү

Санхүүгийн хэлтсийн тооцооны нягтлан
бодогч

Н.Долгормаа